

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/27

Мандалговь


Хөтөлбөр батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хүнс, хөдөө аж ахуйн газрын "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх хөтөлбөрийг 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж, жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллахыг Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн /О.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

Гурав. Хөтөлбөр шинэчлэн батлагдсантай холбогдуулан Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын даргын 2014 оны А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ



120000104

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл,
нийгмийн баталгааг хангах хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилго

ХХААГазрын ажилтан албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах,
нийгмийн баталгааг хангах, мэдлэг чадварыг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах
нөхцөл бололцоогоор хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг ХХААГазрын дарга болон албан хаагчид
хариуцах бөгөөд 2017-2020 онд үе шаттайгаар, жилийн төлөвлөгөө боловсруулан
хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

1. ХХААГазрын гадна талын тохижилтын ажил

- Ажилчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, амрах талбай, сүүдрэвч, усан оргилуур, бие бялдаржуулах өрөөг бий болгон тохижуулах.
- ХХААГазрын барилгуудад засвар хийх барилгын гадна талыг шинэ, шинэлэг байдлаар тохижуулах, цэцэрлэг зүлэгжүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- Байгууллагын ойр орчимын гэрэлтүүлгийг сайжруулах

2. Албан хаагчдын ажлын байрны талаар

- Ажил үүргээ гүйцэтгэх шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгслээр хангах
- Ажлын байрны дотоод зохион байгуулалтыг цаг үетэй нийцсэн, чанарын шаардлага хангасан тохилог байдлаар шийдэх
- Able программын ашиглалтыг сайжруулж, албан хаагчид өөр хоорондоо мэдээ мэдээлэл мэдлэг чадвараа солилцох боломжийг бүрдүүлэх
- Ажлын байрны эрүүл, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийг ажилчдын дунд байнга сайжруулах
- Ажлын байранд ашиглагдаж байгаа эд зүйлсийг тодорхой үе шаттайгаар шинэчлэх

3. Албан хаагчдын сургалтын талаар

- Гадаад, дотоод сургалтанд ажлын шаардлага, хүсэл сонирхолыг харгалзан тогтмол хамруулах
- Албан хаагчдыг мэргэжлээр нь болон бусад чиглэлээр мэргэшүүлэх, хөрвөх чадвар олгох зорилгоор давтан сургах
- Туршлага судлах ажлыг гадаад, дотоодын байгууллага, өөр бусад

аймаг хотуудтай хамтран зохион байгуулах

4. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар

- Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ ажлын үр дүнг харгалзах, цол, эрдмийн зэрэг, зэрэг дэв, мэргэшлийн зэрэг, ур чадварын болон үр дүнгийн шагналын нэмэгдлийг хууль, журмын дагуу олгож байх
- Байгууллагын ажилтан албан хаагчидад түлээ, нүүрс худалдан авах, халаалтын зардалд тодорхой хэмжээний дэмжлэг дотоод журамтай уялдуулан олгоно.
- Байгууллагын ажилчидад орон сууц, хашаа барих, худалдан авахад тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх
- Байгууллагын ажилчдыг өөрсдийн нөөц бололцоогоо түшиглэн ашгийн бусаар туслах аж ахуй эрхэлж, хүнсний ногоо тарьж өөрсдийн хүнсний хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

5. Албан хаагчдын амралт, эрүүл мэнд

- ХХААГазрын ажилтан, албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж байх
- Идэвхитэй амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх спорт өдөрлөг, явган болон тойрон аялалыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.
- 7 хоног бүрийн нэг өдөр тогтмол зааланд тоглож байх.
- Ажилтан, албан хаагчдыг гадаадад эмчлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Аймаг орон нутгаас болон улсын хэмжээнд зохиогдож байгаа өдөрлөг болон спортын арга хэмжээнд албан хаагчдыг оролцоход дэмжлэг үзүүлэх

6. Хөтөлбөрийн санхүүжилт

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг байгууллагын жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- Иргэдээс өгсөн тусламж дэмжлэг
- Байгууллагын ажилчдын дундын фонд